# МОНГОЛ УЛС
# БАЯНХОНГОР АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
# ЗАХИРАМЖ

2021 оны 08 сарын 30 өдөр　　　Дугаар А/537　　　Номгон

Цэргийн дүйцүүлэх албаны "Тусгай үүргийн бэлтгэл" шатны сургалт явуулах тухай

Засгийн газрын 2018 оны 03 дугаар сарын 27-ны өдрийн 80 дугаар тогтоолоор батлагдсан "Цэргийн албыг дүйцүүлэн хаах журам", Засгийн газрын 2018 оны 08 дугаар сарын 15-ны өдрийн "Цэргийн дүйцүүлэх алба хаах иргэдийн тооны дээд хязгаарыг тогтоох тухай" 249 дүгээр тогтоол, аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн 2019 оны 57 дугаар тогтоол, "Журам батлах тухай" Засгийн газрын 2016 оны 215 дугаар тогтоолоор баталсан "Цэргийн дүйцүүлэх албыг мөнгөн төлбөрийн хэлбэрээр орлуулан хаах иргэний тоо бүртгэл хөтлөх, мөнгөн төлбөрийг төлөх, хураан авах, төлбөрийн орлогыг ашиглах" журмын 4 дүгээр зүйлийн 4.1.1,6 дахь заалтуудыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Цэргийн албыг 2020-2022 онд биеэр дүйцүүлэн хааж буй иргэдийн "Тусгай үүргийн бэлтгэл" шатны сургалтыг 2021 оны 09 дүгээр сарын 05-ны өдрөөс 09 дугаар сарын 19-ний өдөр хүртэл 14 хоногийн хугацаатай Зэвсэгт хүчний 143 дугаар тусгай роттой хамтран хээрийн байрлалд зохион байгуулсугай.

3.Цэргийн албыг биеэр дүйцүүлэн хаагчдын хувийн бэлтгэлийг хангуулж, 2021 оны 09 дүгээр сарын 05-ны өдрийн 08:00 цагт бэлэн байлгахыг сумдын Засаг дарга нарт үүрэг болгосугай.

4.Сургалтыг томилогдсон бүрэлдэхүүнтэй сахилга, дэг журмын өндөр түвшинд чанартай зохион байгуулан дүнг илтгэхийг Цэргийн штаб (хурандаа Г.Нэмэхбаяр)-т даалгасугай.

5.Сургалтад шаардагдах зардлыг хавсралтаар баталсугай.

6.Сургалтын зардалд шаардагдах 7.136.080 (Долоон сая нэг зуун гучин зургаан мянга наян) төгрөгийг Цэргийн дүйцүүлэх албаны мөнгөн төлбөрийн орлогын орон нутагт үлдэх хэсгээс зарцуулахыг Цэргийн штаб (хурандаа Г.Нэмэхбаяр)-т зөвшөөрсүгэй.



601 10235

6.Захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Цэргийн штаб (хурандаа Г.Нэмэхбаяр), Санхүү, төрийн сангийн хэлтэс (С.Байгалмаа) нарт үүрэг болгосугай.

ДАРГА Д.МӨНХСАЙХАН

Аймгийн Засаг даргын ...2021... оны ...08... дугаар
сарын 30-ны өдрийн А/537 дугаар захирамжийн
хавсралт

# ЦЭРГИЙН АЛБЫГ БИЕЭР ДҮЙЦҮҮЛЭН ХААГЧИДТАЙ ЯВУУЛАХ СУРГАЛТЫН ТӨСӨВ

| Д/д | Зардлын нэр | | Зардлын тооцоо | | |
|---|---|---|---|---|---|
| | | | Тоо | Нэг бүрийн дүн | Нийт дүн |
| 1 | Хоолны зардал /Цэрэг нормоор/ | | 40 хүн*14 хоног | 7880 төг | 4.412.800 төг |
| 2 | Түлш, модны тооцоо | | $м^3$=82000 ,14 хоног<br><br>Нийт=8.4 $м^3$ | КП-125 /Галлах ам/1* /1 хоолны норм/0.28<br>Ердийн зуух /Галлах ам/1* /1 хоолны норм /0.1/ | 688.800 төг |
| 3 | Сургалтын зардал | | 40 хүн*14 хоног | Дэвтэр-4 ш*1950 төг*40 хүн =312.000 төг<br>Бал-4 ш*795 төг*40 хүн=127200 төг<br>Хавтас-40 ш*2500 төг=100000<br>Бичгийн цаас-8 боодол*14010 төг =112080 | 651.280 төг |
| 4 | Тээврийн зардал | | Фургон-2 | 2*220.000=440.000 төг | 440.000 төг |
| 5 | Авто бензиний тооцоо | Рес- /250км*2/ | Зил-131- /40л/ | Зил-131*200 л*2160=432000 төг | 943200 төг |
| | | Рес- /250км*2/ | Фургон- /18л/ | Фургон-*90л*2130=191700 төг | |
| | | Рес- /250км*2/ | Фургон- /18л/ | Фургон-*90 л*2130=191700 төг | |
| | | Агергат-1/ 1цагт*1.5л/ | | Агергат 60 л*2130=127800 төг | |
| **Дүн** | | **7.136.080** | | | |

_________oOo_________